

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	9
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	12
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	14
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
6.1. Нөхөн сэргээлтийн бодлого .....	22
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	26
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	27
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	28
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	29
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	30
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	32
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	33

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ашиглалтын технологийн үндсэн үзүүлэлтүүд .....	5
Хүснэгт 2. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл.....	12
Хүснэгт 3. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	14
Хүснэгт 4. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....	15
Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	27
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	28
Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	29
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	30
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	32
Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	33

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил .....	4
Зураг 2. Төслийн талбайн районы газрын гадаргын хэвгиййн буюу налуу (градус).....	9
Зураг 3. Байгалийн бүс бүслүүрийн зураг .....	10

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр:** “Элстэйн” хайлуур жоншны ордын төсөл

**Төслийн зорилго, ач холбогдол:**

Хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, эдийн засгийн хувьд үр ашигтайгаар ашиглах, улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

**Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:**


“Скайтимбер” ХХК нь 2013 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах 9011396116 тоот бүртгэлийн дугаар бүхий Монгол улсын аж ахуй нэгжийн гэрчилгээтэй.

Компаний нэр	“Скай тимбер” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011396116
Регистрийн дугаар	5686695
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 8-р хороо, 4-р хороолол, 8-152 тоот
Утас	(+976) 94014848
<b>Ашигт малтмал хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл:</b>	
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-022096
Олгосон огноо:	2022.01.13

Ашигт малтмал, газрын тосны газраас 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдөр зарласан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтаар Цагаан-Өндөр нэртэй XV-0000021651 тоот хайгуулын зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.10.23-ны өдрийн 408 тоот шийдвэрээр “Ган Ресурс” ХХК-д олгосон. “Ган Ресурс” ХХК-аас АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2021.06.03-ны өдрийн 161 тоот шийдвэрээр “Скайтимбер” ХХК-д шилжүүлсэн.

**Төслийн байршил:**

Дундговь аймаг, Өндөршил сум, 1-р багийн нутаг болох Цагаан өндөр нэртэй газарт орших “Элстэйн” хайлуур жоншны ордын 382.26 га талбай бүхий MV-022096 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш зүтг 420км байрладаг. Дундговь аймгийн төвөөс 186км, Чойроос 125км, Өндөршил сумаас баруун хойш 30км зайд байрлана.



Зураг 1. Төслийн талбайн байришил

#### Нөөцийн тооцоо:

Ордын геологийн нөөц: Ордын хэмжээнд нийт B+C зэргээр 34.47%-ийн CaF<sub>2</sub>-ийн агуулга бүхий 51.57 мян.тн хүдэрт 18.8 мян.тн флюоритын нөөцтэй гэж тогтоожээ. Үүнээс хүдрийн биет-1-ийн нийт B+C зэргийн нөөц 23.84 мян.тн хүдэр, хүдрийн биет-2-ийн нийт B+C зэргийн нөөц 17.5 мян.тн, хүдрийн биет-3-ийн нийт B+C зэргийн нөөц 10.1 мян.тн тус тус байна.

Ордын үйлдвэрлэлийн нөөц: Ордыг ил болон далд аргаар ашиглах бөгөөд ил уурхайн оновчлолоор тогтоогдсон хүрээнд нийт (B+C) зэргээр 13.5 мян.тн геологийн нөөц хамрагдах бөгөөд ашиглалтын үеийн хаягдлыг 2.72%, бохирдлыг 4.08%-аар тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц 13.7 мян.тн болж байна. Ил уурхайн хүрээний гадна үлдэж буй 38.0 мян.тн нөөцийг далд аргаар ашиглах бөгөөд уг нөөцдөд далд уурхайн ашиглалтын үеийн хаягдлыг 1.8%-аар бохирдлыг 19.1%-аар тус тус тооцоход үйлдвэрлэлийн нийт нөөц 44.4 мян.тн болж байна. Нийт үйлдвэрлэлийн нөөц нь 58.1 мян.тн болно.

#### Ордын ашиглалтанд бэлтгэгдсэн байдал, нээх ба ашиглах дараалал

Элстэйн хайлуур жоншны орд нь 3 хүдрийн биетээс тогтох ба хүдрийн биетүүд нь харьцангуй жижиг, хүдрийн агуулга бага зэргийг харгалzan үзээд III бүлгийн ордод хамруулсан байна. Хүдрийн биетүүд нь баруун урдаас зүүн хойшоо 60°-аар сунаж баруун хойш 55°- аар унсан, хоорондоо 1.5-3.5 м зйтэй зэрэгцээ судал байдлаар оршдог бөгөөд I хүдрийн биет нь суналын дагуу 50.0 м, газрын гадаргуугаас гүн рүү 70.0 метр хүртэл, II хүдрийн биет нь суналын дагуу 45.0 м, газрын гадаргуугаас гүн рүү 62.0 метр хүртэл, III хүдрийн биет нь суналын дагуу 30.0 м, газрын гадаргуугаас гүн рүү 56.0 метр хүртэл тус тус үргэлжилдэг байна.

## Уурхайн ашиглалтын технологи

Ордыг ашиглах технологи нь уурхайн хүдэр олборлолтын болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, ашигт малтмалын нөөцийг зохистой ашиглахын зэрэгцээ төлөвлөгөөт бүтээлийг хангах ёстой.

Иймд төсөл хэрэгжүүлэгч нь ордын 1194-1164 метрийн түвшинд ил аргаар олборлолт хийж байгаад цаашид 1114 метрийн түвшин хүртэл далд аргаар олборлолт явуулахаар төлөвлөж ТЭЗҮ-г боловсруулсан бөгөөд нийт хүдэр олборлолтын 26.3%-ыг ил аргаар, 73.7 хувийг далд аргаар явуулна.

### Уурхайлалтын хүчин чадал, бүтээгдэхүүн гаргалтын календарчилсан төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайлалтын үйл ажиллагааг 2 жилийн хугацаанд, жилийн 4 улиралд тасралтгүй явуулахаар төлөвлөсөн бөгөөд уурхайлалтын эхний 3-н сард ил уурхайлалтын үйл ажиллагаа явуулж, цаашид далд уурхайлалтын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байна. Уурхайн хүчин чадлыг баяжуулах үйлдвэрийн хүчин чадал зэрэгт тулгуурлан жилд 30 мян.тн хүдэр олборлохоор тооцсон бөгөөд эхний жилд ил уурхайгаас 13.75 мян.тн, далд уурхайгаас 14.3мян.тн хүдэр, 2-дахь жилд зөвхөн далд уурхайгаас 30.16мян.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн.

### Ил уурхайн ашиглалтын технологи

Ордын геологи болон уул техникийн нөхцөл талаас хөрсний гадаад овоолготой, тээвэртэй ашиглалтын технологийг сонгон авсан. Уулын ажлын ерөнхий чиглэл дээрээс доош чиглэсэн байна.

*Хүснэгт 1. Ашиглалтын технологийн үндсэн үзүүлэлтүүд*

№	Ашиглалтын технологийн элементүүд	Хэмжих нэгж	Параметрүүд
1	Ажлын доголын өндөр	M	5
2	Ажлын бус доголын өндөр	M	10
3	Уурхайн ерөнхий хажуугийн өнцөг	Градус	37
4	Ажлын бус доголын хажуугийн өнцөг	Градус	55
5	Ажлын доголын хажуугийн өнцөг	Градус	70
6	Аюулгүйн бермийн өргөн	M	4
7	Ажлын талбайн хамгийн бага өргөн	m	30

Ил уурхайн процесс нь уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой. Уурхайд дараах процессууд явагдана:

- Шимт хөрс хуулалт /15.06мян.м<sup>3</sup>/
- Өрөмдлөг /8.2мянган тууш метр/
- Тэсэлгээ /Эмульсийн тэсрэх бодис ашиглаж, хөрсөнд 7 хоногт , хүдэрт 14 хоногт 1 удаа тэсэлнэ./
- Ухаж ачих /Хуулах хөрсний хэмжээ-133.5мян.м<sup>3</sup>. Уурхайлалтын үр дүнд 0.9 га талбайтай 30м-ийн гүнтэй уурхайн ухаш үүснэ./

- Тээвэрлэх /Хүдэр тээвэрлэлт 1000м, хөрс тээвэрлэлт 800м/
- Овоолох /Сийрэгжилтийн коэффициент-1.3. Овоолгод хураагдах хөрс 173.6мян.м<sup>3</sup>. Овоолго нь 1.9 га талбайтай, 15м өндөр байна./
- Хүдэр ачилт / Уурхайгаас олборлосон хүдрийг уурхайн ам нөхцөлөөр борлуулах бөгөөд гадаад тээврийн автосамосвалд ачилт хийх/

## Далд уурхайн технологи

Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөл ашиглалтын системүүдийн үзүүлэлтүүдээс үндэслэн Элстэйн ордод Давхраар нураах ашиглалтын системээр далд уурхайлалтыг явуулахаар төлөвлөсөн байна.

Өрмийн штрекээс хүдрийн биетэд шпур өрөмдөж, тэслэн хүдрийг нурааж, нураасан хүдрийг ачих-тээх машинаар ачиж, улмаар налуу гол амаар тээвэрлэн газрын гадаргад гарган буулгах процессуудын бүрдэлтэй технологи хэрэгжинэ. Ашиглалтын технологийн агуулгын дагуу дараах ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Хүдрийг өрөмдөж тэслэх / Тэсэлгээний ажилд эмульсийн тэсрэх бодис, искра-ш маркийн дамжуулах утас, цахилгаан бялт тэслүүр зэргийг ашиглана/
- Уурхайн талбайн нөөцийг бэлтгэх /Элстэйн ордын далд уурхайн талбайн нөөцийг ашиглалтад бэлтгэх аргаар энгийн арга болох хэвгий, налуу уналтай ордод ордын дундуур болон хажуугийн чулуулагт хэд хэдэн давхрын штрек нэвтрэхээр сонгосон./
- Далд уурхайн малталтууд бэхэлгээ /Налуу гол ам, тээврийн штрек зэрэг үндсэн малталтуудад трокретон бетон бэхэлгээ, востающий малталтад модон бэхэлгээ хийнэ./
- Хүдрийг ачиж-тээвэрлэн налуу гол аманд хүргэх /XYWJ-1 маркийн ачигч машин сонгосон байна./
- Хүдэр ялгах, ачих, тээвэрлэх зэрэг гадарга дээрх ажиллагаа хийгдэнэ.

## Баяжуулалтын технологи

Элстэйн хайлуур жоншны ордын дээжид технологийн туршилтын ажлыг “Тру Ти Ар Си” ХХК-ийн лабораторид хийлгэсэн. Ордын хүдрийг баяжуулах технологийн туршилтын тайлангаар Элстэйн ордын хайлуур жоншны хүдэрт дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

1. Анхдагч дээжинд хийсэн химийн шинжилгээний үр дүнгээр CaF<sub>2</sub>- 36.41%, CaCO<sub>3</sub>-1.86%, SiO<sub>2</sub>-55.51%, ΣS<0.1%, P<0.01% тус тус агуулгатай, 47.9кг жинтэй дээжинд хийж гүйцэтгэсэн байна.
2. Дундаж эзлэхүүн жин – 2.70 гр/см<sup>3</sup>
3. Тухайн хүдэр дэх үйлдвэрлэлийн ач холбогдолтой эрдэс нь флюорит.
4. Хүдрийн дээжийг -75 мкм (83%) нунтаглаж, флотацийн аргаар баяжуулж 37.73%-ийн гарцтай, кальци фтор 97.03%-ийн агуулгатай, 97.08%-ийн жонш авалттай флюоритийн ФФС-97Б чанарын баяжмал гарган авах боломжтой болохыг тогтоосон.

Элстэйн ордын ашиглалтын жил, ордын нийт нөөц болон үйлдвэрлэлийн нөөцөөс шалтгаалж төсөл хэрэгжүүлэгч нь олборлосон хүдрийг уурхайгаас 110 км зайд байрлах

“Шашир Оргил” ХХК-ийн баяжуулах үйлдвэр рүү тээвэрлэн тус үйлдвэрт Элстэйн ордын хүдрийг баяжуулахаар төлөвлөж байна. Орд ашиглалтын хугацаанд уурхайгаас олборлох хүдэр олборлолтын төлөвлөлтөөс харахад төслийн нийт хугацаанд 31.58% дундаж агуулгатай, 58.19 мян.тн хүдэр олборлон баяжуулах үйлдвэрт нийлүүлэхээр тооцоолол гарсан.

### Уурхайн ажиллах горим

Уурхай нь жилийн турш тасралтгүй ажиллах бөгөөд нэг ростерт 56 ажилтан хоногийн 2 ээлжээр ажиллана.

### Уурхайн дэд бүтцийн хангамжийн асуудал

Гадаад цахилгаан хангамж: Уурхай нь төвлөрсөн цахилгаан сүлжээнд холбогдоогүй ба хэрэглээний цахилгааныг 100 кВт-ийн 2 ширхэг дизель генераторуудаар хангана.

Дулаан хангамж: Тус уурхай нь жилийн турш тасралтгүй горимоор ажиллахад өвлийн улиралд далд уурхайд өгөх агаарыг +2°C хүртэл халаахаар төсөлд тусгасан тул далд уурхайд орж ирэх газрын дээр байсан агаарын уур амьсгалын параметрүүд (температур ба харьцангуй чийглэг) өөрчлөгднө. Зуны улиралд агаарын температурыг нэмэгдүүлэх шаардлагагүй. Уурхайд байрлуулах калорифер нь 11-р сарын 5-аас 4-р сарын 1 хүртэл нийт 106 хоног буюу 2226 цаг ажиллана.

Уурхайд цахилгаан эрчим хүчээр ажилладаг дугуй хэлбэрийн хөндлөн огтлолтой агаар дамжуулагч бүхий НК төрлийн калорифер тусгаж байна. НК төрлийн калорифер нь цахилгаан зарцуулалт багатай, автомат тохируулагчтай, зэвэрдэггүй гангаар хийгдсэн, харьцангуй хямд үнэтэй зэрэг давуу талуудтай.

Далд уурхайн агааржуулалт: Хүдэр олборлолтын үед уурхайд нэг ээлжинд дунджаар 10 хүн ажиллахаар тооцлоо. Мөн хэвтээ болон босоо малталтыг хөндлөн огтлолын талбай, гүнээс нь хамааруулан цэвэр агаарыг вентиляторын тусламжтайгаар уурхайд шахаж оруулах аргыг ашиглана. Агааржуулахдаа босоо малталтыг 12 м-ээс дээш гүн нэвтрэх үед ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах үүднээс 11кВ-ын хүчин чадалтай вентилятор, агааржуулалтын хоолойн тусламжтайгаар агааржуулна. Агааржуулалтын хоолойн төгсгөл нь хэвтээ болон босоо малталтын мухар мөргөцгөөс 6-8 м-ээс багагүй зайд байрлана. Өрөмдлөг тэсэлгээний ажил хийсний дараа малталтыг бүрэн агааржуулж /30 минутаас доошгүй/ бохир агаарыг зайлцуулсны дараа ажлаа эхэлж байх шаардлагатай. Уурхайг байнга агааржуулж байх ба уурхайн агаарын найрлагыг тусгай зориулалтын багажаар хэмжиж мэдээллийн сан хөтөлж байх шаардлагатай.

Агааржуулалтын схем, агааржуулалтын аргын сонголт Ордыг нээх схем, ашиглалтын систем, ордын уул-геологийн тогтцын онцлогоос хамааруулж жигүүрийн агааржуулалттай аргаар агааржуулах схемийг сонгон авлаа. Далд аргын хувьд цэвэр агаарын урсгал нь налуу гол ам → тээврийн штрек → тээврийн орт → өрмийн штрек → олборлолтын мөргөцөг → өрмийн штрек → тээврийн орт → тээврийн штрек → квершлаг → вассстающийг дамжин бохирдсон агаар гадагшилна.


**Усан хангамж:** Усны хэрэгцээг унд ахуйн хэрэгцээний ус, далд уурхайн технологийн хэрэгцээний ус, тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаанд шаардлагатай усны хэрэгцээ гэж ангилсан бөгөөд хэрэгцээг худгаас хангана.

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БҮЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга


Төсөл хэрэгжиж бүй талбай нь Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн хойд хэсэгт шилжилтийн заагаар орших ба газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээрээ ухаа гүвээт талархаг, дов толгодлог гэсэн 2 төрлийн рельеф зонхилен. Ухаа гүвээт талархаг рельеф нь цэrdийн хурдас тархсан хэдэн арван км үргэлжлэх урт хөндийнүүд тохиолдоно.

Гуу жалгаар харьцангуй муу хэрчигдсэн, маш налуу хажуутай мөлгөр оройтой байдаг. Далайн түвшнээс 1080-1300 м өндөрт өргөгдсөн бөгөөд ургамалжилтын хувьд Дорноговийн цөлөрхөг хээрийн тойротг хамаарна. Сумын нутаг дэвсгэр нь тэгш тал, нам хотгор, хоолой, бэсрэг уулс дагалдана.



Зураг 2. Төслийн талбайн районы газрын гадаргын хэвгийй буюу налуу (градус)

**Байгалийн бүс бүслүүр:** Элстэйн жоншны орд нь байгалийн бүс бүслүүрийн хувьд говийн бүсэд хамаарч байна.



Зураг 3. Байгалийн бус бүслүүрийн зураг

### Үнэмлэхүй байрлал

Дундговь аймгийн Өндөршил сум нь нийт 485.2 мян.га нутагтай. Үүнээс 482.7 мян.га хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 1.5 га ойн сан, 2.5 мян.га усан сан, зам шугам сүлжээ, тусгай хэрэгцээ, төв суурины газар тус тус эзэлдэг.

### Харьцангуй байрлал

Дундговь аймгийн зүүн урд хэсэгт, Дорноговь аймагтай залгаа буюу хойд хэсэгт говийн бүсэд багтах их говийн бүсийн хэсэгт байрладаг. Сумын нутаг дэвсгэр нь д.т.д 1080-1300 м өргөгдсөн. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хувьд 99.4% буюу 482.7 мян.га талбай эзэлдэг.

### Цаг агаар, уур амьсгал:

Сумын хувьд нарны нийлбэр цацраг жилд дунджаар нутгийн хойд хэсгээр 1400 квт.цаг/м<sup>2</sup>, төв хэсгээр 1400-1500 квт.цаг/м<sup>2</sup>, өмнөд хэсгээр 1500 квт.цаг/м<sup>2</sup> ба түүнээс дээш байна. Уулын бэл хажуугаар нарны нийлбэр цацрагийн хэмжээ 1250-1350 квт цаг/м<sup>2</sup> байдаг. Тус сумын хувьд нэг жилд нар гийгүүлийн дундаж хугацаа нутгийн хойд хэсгээр 3000-3100 цаг, төвийн хэсгээр 3100-3200 цаг, өмнөд хэсгээр 3200 ба түүнээс дээш цаг байдаг байна.

### Агаарын даралт, салхи

Өндөршил сумын хувьд монголын хамгийн их салхитай байдаг нутаг юм. Энэ нь манай орны хойд ба өмнөд зүгийн агаарын урсгалын хооронд оршдог учраас их салхитай байдаг. Агаарын 1 дүгээр сарын дундаж даралт нутгийн баруун хойд хэсгээр 846-848 гПа, бусад нутгаар 844 - 846 гПа. Харин 7 сарын байдлаар 842 - 844 гПа байдаг байна. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 21, 15 м/с ба түүнээс хүчтэй салхитай өдрийн

тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10-аас дээш, явган шуургатай өдрийн тоо жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 40 м/с хүрч байсан.

Тус сумын нутагт агаарын температур ОЖД-аар 1.1-4.7 градусын хооронд хэлбэлздэг байна.

Хамгийн хүйтэн 1 дүгээр сар агаарын дундаж температур -16.7 градусаас -19.6 градус байхад агаарын үнэмлэхүй хамгийн бага -39.7 градус байна. Хамгийн дулаан 7-р сард агаарын температур 19.9 градусаас 22.3 градус байхад агаарын үнэмлэхүй их температур 2000 оноос хойш 41.3 градусаас буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд агаарын дундаж температур 2.6 градусаар дулаарсан байна. Их хүйтэн өдрийн тоо нийт нутгаар 10 ба түүнээс доош байна. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110-130 өдөр бол агаарын температурын хоногийн дундаж +100C ба түүнээс дээш байх өдрийн тоо 130-150 өдөр юм.

**Хөрсөн бүрхэвч:** Судалгааны талбай нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их мужид хамаарна. Энд хур чийг бага, хөрсний органик үлдэгдлийн хэмжээ мөн бага ургамал тачир сийрэг. Төслийн талбайн урд хэсгээр үлдмэл нутаг хөрс, хойд хэсгээр цөлөрхөг хээрийн бор хөрс тархжээ. Үүнд уул, цав толгодоор нь цөлөрхөг хээрийн уулын бор хөрсний 2 төрөл болох цөлөрхөг хээрийн уулын бор хөрс, сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс зонхилон тархах ба эдгээр хөрс нь заримдаа эх чулуулгийн илэрц, сайр гуу жалгын хөрстэй бүрдэл үүсгэн тархана. Мөн уулын цайвар хүрэн хөрс ч зурvasхан орж ирнэ. Гадаргадаа дунд зэрэг чулуутай байхаас гадна хааяа чулуурхаг байна.

**Ургамлан нөмрөг:** Тус төслийн талбай нь ургамлан бүрхэвчээр тачир сийрэг ургамалтай бөгөөд жижиг дэгнүүлт үетэн тархсан байна. Тус орд нь тал хээр,.gov хээрийн мужид багтдаг учраас ургамлын хөрсний үеийн зузаан 0.05-0.2м хааяа 0.3м хүрдэг. Тал, хөндий, энгэр, бэл газраар таана, хөмүүл, агъ зэрэг.govийн шимт ургамал ургахаас гадна шарилж, зангуу, толгодын орой хажуугаар хялгана, хазаар өвс, монгол өвс зонхилж ургана. Бутлаг ургамлаас бор харгана, алтан харгана голлон ургана.

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** Дундговь аймаг Өндөршил сум нь 2011 онд хүн амын улсын нийт тооллогоор нийт 1504 хүн бүртгэгдсэн бөгөөд даруй 10 жилийн хугацаанд 1442 болж буурсан үзүүлэлттэй байна. Тус сум нь засаг захиргааны нийт 3 багтай бөгөөд хүн амын хуваарилалт тэнцүү амьдарч байна.

Дундговь аймгийн Өндөршил сум нь Улаанбаатар хотоос 420 км, аймгийн төвөөс 186 км зайд орших бөгөөд, урд болон зүүн талаараа Дорнговь аймгийн Мандах, Сайхандулаан, Айраг, Даланжаргалан сум, хойд болон баруун талаараа өөрийн аймгийн Баянжаргалан, Гурван сайхан, Өлзийт сумдтай хиллэдэг ба 485.2 мянга газар нутагтай. Мөн тус сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болсон 2 багтай. Мөн Мобиком, Жи-Мобайл, Юнител, Скайтэлын үүрэн телефоны нэгдсэн сүлжээ болон шилэн кабель ашиглаж өндөр хурдны интернетэд холбогдсон.

Сумын газар нутаг дээгүүр Дундговь-Дорнговь-Замын-үүдийг холбосон, Говьсүмбэр-Цагаансуврагыг холбосон шороон замууд дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог зэргээр дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутаг юм.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

“Скайтимбэр” ХХК-ийн Дундговь аймгийн Өндөршил сумын нутагт хэрэгжүүлж буй MV-022096 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлтэй элстэй хайлуур жоншны ордыг ашиглахтай холбоотой үйл ажиллагаанаас төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин түүний бүрдэл хэсгүүд (агаар, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймаг, гадаргын болон газрын доорх ус), ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэнд, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилд үзүүлж болзошгүй нөлөөллүүд тэдгээрийн хэлбэр, хугацаа, эрчмийг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

*Хүснэгт 2. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл*

Байгаль орчны үзүүлэлт	Шүүд	Шүүд бус	Өөрөөр зохицууллагдах	Богино хугацааны	Үргт хугацааны	Будаж нөлөөлөх	Буналгийн нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсцын өөрчлөлт			x	x						
Гадаргын урсцын өөрчлөлт			x	x						
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x		x	x			
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x		x	x			
Геологийн тогтцын өөрчлөлт	x			x		x	x			
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x							x	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг	x			x					x	
Бэлчээрийн байдал		x		x						
Эрдэс туухий эдийн нөөц	x			x					x	
Эрчим хүчний нөөц	x			x					x	
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Газрын доорх усны чанар, хэмжээ			x	x						
Гадаргын усны чанар хэмжээ			x	x						
Агаарын бохирдол			x	x						
Хөрсний бохирдол			x	x						
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x	x						
Дуу чимээ, шуугианы нөлөө		x		x					x	
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x			x					x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x			x					x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x	x						
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x	x						
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x	x						
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+			+					+	
Үйлчилгээний салбарын у/а-нд нөлөөлөх		+		+						+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх	+			+					+	

Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x	x					
6. Эдийн засагт узүүлэх нөлөө									
Татварын орлого өөрчлөгдөх	+				+				+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+				+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+				+
Ажлын байр нэмэгдэх	+				+				+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+				+
7. Бусад нөлөөлөл									
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x		x				
Дүн	14	4	13	0	30	0	3	3	8
									7

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Уурхайн олборлолт үйл ажиллагааны улмаар хөрс хуулах, олборлолт зэргээс хөрсөн бүрхэвч ухагдаж, ургамлан нөмрөг талхлагдаж урт хугацаанд шууд хүчтэй нөлөөлнө;
- Уурхайн олборлолтын ажлын улмаас геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр шууд урт хугацаанд дунд зэрэг нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид зэргээр нөлөөлнө;

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;
- Ордын олборлолтын үйл ажиллагааны үр дүнд дуу чимээ нь шууд бусаар урт хугацаанд сөргөөр нөлөөлнө;

*Богино хугацааны нөлөөлөл:*

- Төслийн үйл ажиллагааны явцад дуу чимээ тодорхой хугацаагаар ихэснэ.

*Хүчтэй нөлөөлөл:*

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хөрс болон ургамлан, геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

#### 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

*Хүснэгт 3. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (мян төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	3125.0
2		
3		
4		
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1733.0
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1500.0
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	
8	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
9	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
11	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бусийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
	Нийт зардал	6358.0

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг бид хэрэгжүүлсэн.

*Хүснэгт 4. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ*

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>Агаарын чанар</b>									
1	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд:	Хуурайшилт ихтэй өдрүүдэд дотоод зам талбайн усалгааг	Уурхайн зам	m <sup>3</sup>	Үйл ажиллагааны зардал	2024 он			- Байгаль орчныг хамгаалах тухай хууль - “Агаарын тухай”, “Агаарын бохирдлын тухай төлбөрийн тухай” хууль MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд)
2	Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт	Овоолгыг салхи ихтэй Уед услах арга хэмжээ авах, тэдгээрийн гадаргууг ургамалжуулах	Уурхайн зам	m <sup>3</sup>	Үйл ажиллагааны зардал	2024 он			- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
3		Тээврийн хэрэгслийн татвар төлөх Машин механизмуудын графикийн дагуу засвар үйлчилгээ явуулж, сайн чанарын шүүлтүүр, түлш шатахуун ашиглах.	Төсөлд ашиглах машин механизм	-	950.0	1	950.0	2024 он	

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

	Жил тутам агаарын бохирдол үүсгэгч хорт хий, тоосжилтын хэмжилт хийлгэж мэдээллийн сан үүсгэх	Машин механизм	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.			2024 он	
4	Агаарын бохирдлын төлбөрийг тогтоосон хугацаанд төлж байх	Төслийн талбайд	- Үйл ажиллагааны зардал			2024 он	
5	Жил тутам агаарын бохирдол үүсгэгч хорт хий, тоосжилтын хэмжилт хийлгэж мэдээллийн сан үүсгэх	Уурхайн зам	m <sup>3</sup>	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.			2024 он
<b>Нийт</b>						<b>950.0</b>	
<b>Гадаргын ба газрын доорх усны нөөц</b>							
6	Үнд ахуйн ус бохирдох	Төслийн хэрэгжилтийн хугацаанд үерийн уснаас хамгаалах, Үерийн усыг чиглүүлэн урсгах далан, суваг, шуудууг бэлтгэх бөгөөд ашиглалтын дараа нөхөн сэргээх, байгалийн голдирол эвдэрсэн тохиолдолд нөхөн сэргээж, унаган төрх байдалд нь ойртуулах, ус үл тогтох нөхцөлийг бий болгох	Гүний худаг	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 0900: 2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ</li> <li>- Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам</li> </ul>

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

7	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	2024 он		
	Усалгаа болон ахуйн усны хэрэглээг тооцох	Гүний худаг	-	Үйл ажиллагааны зардал	2024 он		
	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Гүний худаг		Үйл ажиллагааны зардал	2024 он		
<b>Нийт</b>				<b>0.0</b>			
<b>Хөрсон бүрхэвч</b>							
8	Хөрсний бүтцэд гарсан оөрчлөлт  Хөрс хатуу, шингэн хог	Шимт хөрсний овоолго, үржил шимт хөрсийг хуулах, нөхөн сэргээлтэд ашиглахаар хадгалах,	Хуулсан шимт хөрс	$m^3$	Үйл ажиллагааны зардал	2024 он	MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

9	хаягдлаар бохирдох	Онц шаардлагатайгаас бусад талбайд үйл ажиллагаа явуулахгүй байх, орчны газар эвдрэхээс аль болох зайлсхийж, автомашин явах зам, зогсох талбайг нарийн тогтоох	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал	2024 он	MNS 5850:2006 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис. Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед уржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт /Техникийн ерөнхий шаардлага/ MNS 5918:2023
		Ашиглагдахаа больсон талбайг хэлбэржүүлэх, нөхөн сэргээлтэд бэлдэж засаж байх	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал	2024 он	- Эвдэрсэн газрыг Ургамалжуулах техникийн Шаардлага Байгаль орчныг хамгаалах тухай хууль /21.3/ БОНБҮ тухай хууль Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль /6.1, 6.2, 7.2, 9.3/ Хог хаягдлын тухай хууль /9.2/
		Засвар үйлчилгээ, шатах тослох материалаар машин техникийг цэнэглэхдээ ШТМ алдагдсан ч хөрсөнд нэвчихээргүй байх аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч байх /пелонк дэвсэх, бетондсон талбай бэлтгэх зэрэг/ ШТМ хөрсөнд алдагдсан үед хусаж авах, саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ	Төслийн талбайд	ш	-	1 200.0	2024 он

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

		авах, шаардлагатай багаж материалыг бэлтгэх /элс хайрга, хүрз, ус, саармагжуулагч бодис гэх мэт/							
		Ашиглалтын хугацаанд хөрсөнд хунд металл, хортой бодисын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү илэрвэл саармагжуулах арга хэмжээ авах, бохирдсон хөрсийг хуулж авах арга хэмжээ авах	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал		2024 он		
		Хаягдлын санд байгаа хаягдал чулуулаг болон лагийг саармагжуулах, дээж авч шинжлэх, байгальд өөрийн замаар задрахгүй органик бодис, хүнд металлууд, аюултай бохирдуулах бодис зэргийг саармагжуулах технологийг хэрэглэх	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал		2024 он		
<b>Нийт</b>						<b>1 200.0</b>			
<b>Газрын хэвлэй</b>									
10	Газрыг үр ашиглгүй, зохисгүй ашигласнаар газрын шим тэжээл буурах	Онц шаардлагатайгаас бусад талбайд гадаргын хэв шинжид нөлөөлөхгүй байх, үйл ажиллагаа	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал	2024 он	- Газрын тухай хууль - “Газрын тухай” хууль - “Байгаль орчныг хамгаалах ухай” хуул:		

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

		явуулахгүй байх, эвдэгдсэн талбайн бүртгэл явуулах, хяналт тавих, энэ талаарх үүргийг холбогдох ажилтанд өгөх						- “Газрын хэвлэлийн тухай
11		Шимт хөрсний овоолгыг байрлуулах талбайг үер ус, салхины нөлөөлөлд өртөхөөргүй газарт сонгох, талбайн бүртгэлийг хийж байх, талбайг аль болох бага байлгах арга хэмжээ авах	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал			2024 он
12		Хаягдал усны болон лаг шаврын тунгаагуурыг нөхөн сэргээх	Төслийн талбайд	га	Үйл ажиллагааны зардал			2024 он
13		Уурхайн орчныг тэмдэгжүүлэх, хил хязгаар тогтоох	Төслийн талбайд	Ш	1 -35000	10	350.000	2024 он
<b>Нийт</b>						<b>350.0</b>		
<b>Ургамлан бүрхэвч</b>								
14	Уурхайн нөлөөллөөс болж ургамлан бүрхэвч доройтох, хомсдох, устаж угүй болох цаашид бэлчээрийн доройтолд орох	Уурхайн зөвшөөрлийн талбай болон түүний ойр орчмын талбайн ашиглалтыг бэлчээр эдэлбэрийг хэвийн хадгалахад сум багийн удирдлагуудтай хамтран ажиллах	Уурхай орчим	Удаа	Үйл ажиллагааны зардал			2024 он
15		Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа эхлэхээс	Хөрсний нөхөн сэргээлт хийж дууссан талбайн хэсгүүдийг ургамалжуулахад зориулж үр суулгацыг туршиж бэлтгэсэн байх	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардал			2024 он
		Tөсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа эхлэхээс	Tөслийн талбайд	M <sup>2</sup>	Үйл ажиллагааны зардал			2024 он

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

	өмнө эвдэрсэн газар болон хайгуулаар эвдэрсэн талбайнуудад хөрс ургамлын нөхөн сэргээлт явуулна. Нөхөн сэргээлтийн Мэргэжлийн хүмүүсийн оролцоотой, тэдний заавар зөвлөмжөөр гүйцэтгэнэ.					
	<b>Нийт дүн</b>		<b>2 500.0</b>			

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 6.1. Нөхөн сэргээлтийн бодлого

Бид орчны тохижилт нөхөн сэргээлтийн ажлыг хүрээнд “Тэр бум мод үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Өндөршил сумын ЗДТГ-аас зааж өгсөн газарт тус бүр нь 250 ширхэг мод тарьж өгөх бөгөөд 1500,000 сая төгрөгийг төлөвлөөд байна.

Мөн 2024 онд уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг Монгол улсын хууль тогтоомжийг дагаж, компани стратеги төлөвлөгөөнд туссаны дагуу, дараах зарчмуудыг баримтлан боловсруулна. Үүнд:

- Бүс нутгийн биологи, нийгэм-эдийн засаг, хууль эрх зүйн орчныг тодорхойлсон үндсэнд хаалтын дараах уурхайтай бүс нутгийн хүн ам, байгаль орчин хэрхэн зохицох талаар төсөөлөл бий болгох
- Компанийн тогтвортой хөгжилд чиглэсэн өнөөгийн бодлогыг тодорхойлж, тогтвортой хөгжлийг бий болгох бусад чиглэлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тогтвортой хөгжлийн шалгуурыг тодорхойлох
- Уурхайлалтын явцад бий болсон дэд бүтцийг эртнээс тодорхойлж, уурхайн үйл ажиллагаагаар эвдэrsэн газрыг хаалтын дараа ашиглаж болох тохиромжтой хувилбарыг сонгох
- Хаалтын дараа тогтвортой хөгжилд оруулах уурхайн бодит хувь нэмрийг тодорхойлох

Дээрх алхмуудын үр дүнд үндэслэн уурхайн хаалтын төлөвлөгөөг дунд хугацаанд шинэчлэх боловсруулах ажлыг хийнэ.

### 6.2. Нөхөн сэргээлтийн нөөц бүрдүүлэх

#### 6.2.1 Шимт хөрсний нөөц бүрдүүлэх, хамгаалах

Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбай, хөрсний овоолго хийгдэх талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэж, стандартын дагуу хамгаална. Мөн нийт шимт хөрсний нөөцийн дэлгэрэнгүй бүртгэл үүсгэнэ.

Уурхайн олборлолтын талбайгаас зүүн урд тал /хэсэг/-д 1-р овоолгоор 17 мян.м<sup>3</sup>, 5-р овоолгоор 13 мян.м<sup>3</sup> эзэлхүүнтэй шимт хөрсний овоолго үүсгэх бөгөөд MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хийж гүйцэтгэх, мөн тэгшилгээ-хэлбэржүүлэлтийн ажлуудыг хийж явуулахаар төлөвлөгдсөн.

Шимт хөрсний нөөцийг хамгаалах, хадгалах зорилгоор шимт хөрсийг нүүрсний уугилтыг дарж аюулгүй байдлыг хангах үүднээс гал дараад ашиглахгүй байх, тусад нь уурхайн ахилтын талбайгаас хуулах хөрснөөс шимэрхэг чулуулгийн овоолго үүсгэж, түүгээр нүүрсний уугилтыг дарах нөхцөлийг бүрдүүлэх, зохион байгуулалттай ажлыг хийхээр төлөвлөж байна.

#### 6.2.2 Модлог ургамлын нөөц бүрдүүлэх, ногоон байгууламж байгуулах

Дээрх ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагуудын нөхөн сэргээлтийн стандартыг баримлан хүлэмж болон мод үржүүлгийн талбай байгуулах, тэдгээрт туршилтын байдлаар

нутгийн ургамлын үр-хайлаас, улиас, сухай зэргийн суулгацыг үржүүлэх, үүнд хүлэмжийн ба бороожуулагч усалгааны систем ашиглах, мөн бусад техник, багаж хэрэгслээр MNS 5918:2008 стандартыг баримтлан уурхайн оффис, хяналтын талбайд тарьцыг шилжүүлэн суулгахаар төлөвлөсөн.

### 6.2.3 Органик бордооны нөөц бүрдүүлэх, ашиглах

Хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, ургамлын ургалтыг дэмжих зорилгоор хүнсний хаягдал, ялзмаг үүсгэх чанартай органик бордоо бэлтгэнэ. Нөхөн сэргээлт хийгдэх талбайд хөрсний чанарыг сайжруулах зорилгоор, MNS 6507:2015 стандарт /Техникийн, эрүүл ахуйн шаардлага/-ыг мөрдлөг болгон ашиглана.

## 6.3 Нөхөн сэргээлтийн туршилт

### 6.3.1 Туршилт

Өмнөх 2011 оноос хойш хийгдэж байсан нөхөн сэргээлтийн туршилтын ажлын хүрээнд тарьц шилжүүлэн суулгах, талбайг зүлэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх бөгөөд нутгийн ургамлыг тарьж ургуулах, үрийн нөөц бүрдүүлэх, ургамлуудаас үр болон мөчир суулгац үржүүлэх, мөн хөрсний чанарыг нэмэгдүүлж, ургалтын үр дүнг сайжруулах зорилгоор туршилтын чиглэлд органик үлдэгдэл, хүнсний хаягдаар бордоо боловсруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөв.

### 6.3.2 нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний ерөнхий хуваарь

Хаврын улиралд:

- Жилийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах
- Нарийвчилсан судалгаа хийх, мэргэжлийн байгууллагуудтай нөхөн сэргээлт, хог хаягдлын саармагжилт, тоосжилтыг багасгах чиглэлээр хамтран ажиллах бэлтгэлийг хангах
- Туслах хүн, хүчний асуудлыг шийдвэрлэх
- Модлог ургамлыг бордох, шилжүүлэн суулгах бэлтгэл ажил
- Гүний худаг гаргах, тоноглох, тоолууржуулах /зөвшөөрөл авах/
- Хашаа хайсыг засаж, янзлах, өргөтгөх
- Нутгийн ургамлын үр цуглуулах /орон нутгаас зөвшөөрөл авах/

Зуны улиралд:

- Тарималжуулах туршилт хийх, тэмдэглэл хөтлөх
- Таримал ургамлын усалгаа, арчилгааг үргэлжлүүлэх, усалгааны системыг хянах, засварлах

Намрын улиралд:

- Модлог ургамлын тарьц бүхий талбайд бордоо хэрэглэх
- Нутгийн ургамлын үр цуглуулах
- Тарималжуулалтын үр дүнг дүгнэх, цэнэг усалгаа хийх

Өвлийн улиралд:

- Тарималжуулах мөчир бэлтгэх
- Тайлагнах, төлөвлөгөө боловсруулах

## 6.4 Техникийн нөхөн сэргээлт

### 6.4.1 Хайгуулын ажлын нөхөн сэргээлт

Гэрээт буюу гүйцэтгэгч байгууллагын өрөмдлөгийн болон уулын ажил явуулсаны дараа зохих стандарт /MNS 5915:2000/-ын дагуу техникийн нөхөн сэргээлт хийж орчныг аюулгүй болгох, байгаль орчинд халтай өөрчлөлтийг арилгах арга хэмжээ авах шаардлагуудыг гүйцэтгэлийн гэрээнд тусгасан байх. Ашигт малтмалын тухай хуулийн 38-р зүйлийг баримтлан, мөрдлөг болгон ажиллана.

### 6.4.2 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт

Уурхайлалтын шууд болон шууд бус үйл ажиллагааны нөлөөнд өртсөн талбайн хэмжээнд дахин /удаан хугацаагаар/ ашиглагдахгүй газарт техникийн нөхөн сэргээлт хийж биологийн нөхөн сэргээлт явуулахад бэлтгэнэ.

Техникийн нөхөн сэргээлт хийх талбай: орон нутагтай талбайн байршлыг тохиролцсоны үндсэнд уурхайн амнаас засмал зам хооронд жонш тээвэрлэсний улмаас эвдэрсэн талбайг хамран хэрэгжүүлнэ.

- Талбайн хүрээг тодорхойлж, байршлыг оролцогч талуудад мэдээлэх
- Техник нэвтрүүлэхээс хамгаалж, талбайн хүрээгээр саад байгуулах болон тэмдэгжүүлэх
- Ургамалжилт, топографи болон хөрсний чанарт үнэлгээ хийх
- Хөрсний чанарыг сайжруулах арга хэмжээ авах /эхний жил/
- Ургамалжуулалт, биологийн нөхөн сэргээлтийн явц /2 дахь жил/
- Мониторингийн явц /3 дахь жилийн хугацаанд/

## 7. **БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг уурхайн 2 дах жилээс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн бөгөөд 2024 оноос уурхай төсөл хэрэгжиж эхэлж байгаа болно.

## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайлуур жоншны ордын ашиглалтын талбайд ямар нэг барилга байгууламж, айл, айлын өвөлжөө, хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх болон, нөхөн олговор олгох арга хэмжээ хийгдээгүй болно.

Гэсэн хэдий ч цаашид нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговортой холбоотой асуудал гарвал газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд: Үндсэн хууль (1992), Газрын тухай хууль (2002 нэмэлт өөрчлөлт 2017.06.09), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003, нэмэлт өөрчлөлт 2017.02.02), Иргэний тухай хууль (2002, нэмэлт өөрчлөлт 2017.05.18) зэрэг болно.

## 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэм жээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Археологийн дурсгал	Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагууд ад заавал мэдэгдэх ёстой.	Уурхайн ашиглалтын нийт талбайн хэмжээнд	-	Тухайн үед нь шийдэх		Үйл ажиллагaanы турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
2	Палеонтологийн дурсгал							
<b>Нийт дүн</b>								-

## 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

№	Болзошгүй аюул, осол, сорөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшигийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Уурхайн нийт ажилчид	1 удаа	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд 1 удаа	Гамшигаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)	
2	Галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Галын аюул эрсдэл	Иж бүрэн	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	2024 он	<ul style="list-style-type: none"> <li>- Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм</li> <li>- MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага</li> </ul>	
3	Осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх	ХАБЭА-г хамгаалах зорилгоор нийт ажилчдад ажлын хувцас, бээлий, малгайгаар хангах.	Уурхайн нийт ажилчид	10 хүн	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд 1 удаа	<ul style="list-style-type: none"> <li>- MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”</li> </ul>	
4		Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусlamжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Төслийн талбайд	Иж бүрэн	75.0	225.0	Жилд 1 удаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль</li> </ul>
5		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас. хэрэгслээр хангах			Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах			
6		Ажилчдыг жил бүр эмнэлгийн үзлэгт хамруулах			Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах			
	<b>Нийт дүн</b>					<b>225.0</b>		

## 11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Xүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө*

№	Хог хаягдлын ангилаал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ э	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн								
2	Үйлдвэрийн	Хог хаягдлын нэгдсэн цэг тохижуулах ангилан ялгах хогийн сав байршуулах Сумтай хийсэн хог тээрийн гэрээний дагуу хог хаягдлын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн сард 1-р удаа сумын төвлөрсөн хогийн цэгт зөөвөрлөн хаях	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	кг	400.0	400.0	Хог хаягдлыг зайлзуулах Сард 1-2 удаа	Хог хаягдлын тухай хууль	
3	Шингэн хог хаягдал	Сав газраас бохир усны гэрээ байгуулах	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	тн	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 он			
4	Хог хаягдлын асуудлын хэмжээнд авч хэрэгжүүлэх	Хог хаягдлын бүртгэл хөтлөх, тайлагнах мэдээг гаргаж хэвших	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	Удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах	2024 он			
	<b>Нийт дүн</b>					<b>400.0</b>			

## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

*Xуснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэг байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								
1	Агаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох зорилгоор CO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> болон нийт тоос, дуу чимээ зэрэг үзүүлэлтийг тодорхойлох	Ил уурхайн салхины чиглэл доор- 1 цэг	2024 он	Жилд 1 удаа	73,000.0	73,000.0	-	MNS 4585:2016
Хөрсөн бүрхэвч								
2	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд хөрсний хүнд металлын зарим элементүүд (Pb, Zn, Cd, Cr, Ni, Co)-ийг тодорхойлох	Ил уурхайн ойролцоо - 2 цэг	2024 он	Жилд 2 удаа	65,000.0	260,000.0	-	MNS 5850:2019
Усны чанар								
3	Усны чанарын үндсэн үзүүлэлт болон анион, катион, хүнд металл	Үнд, ахуйн хэрэглээний худгаас -1 цэг	2024 он	Жилд 2 удаа	50,000.0	100,000.0	-	MNS 0900:2018
4	Ахуйн болон үйлдвэрлэлийн хаягдал усны ерөнхий химийн болон бактерлогийн шинжилгээ	Хаягдал ус – 1 цэг	2024 он	Жилд 2 удаа	50,000.0	100,000.0		MNS 4943:2008
Амьтны аймаг								
4	Амьтны ажиглалт судалгаа, мониторинг хийх	Төслийн талбай болон ойр орчмын өндөрлөг цэгт	2024 он	Жилд 1 удаа	600,000	600,000	-	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй, ажиглалт бүртгэл
Ургамлан бүрхэвч								
4	Ургамлын мониторинг хийх	Төслийн байгууламжийн талбай дахь судалгааны цэг Төслийн талбайд ойр орших ургамлын бүлгэмдлийн хяналтын цэг	2024 он	Жилд 2 удаа	300,000	600,000	-	Баталсан арга зүй

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭЛСТЭЙН” ХАЙЛУУР  
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ / 2024 ОН /

	<b>Нийт</b>	<b>1 733,000.0</b>		
--	-------------	--------------------	--	--

### 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үрьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
			2023 он						
			Cap	Cap	Cap				
1	2	3	4	5	6	7			
1	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох	7	-	-	Уурхайн удирдлага	-		
2	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 <sup>1</sup> болон БО-ны өрөнхий үнэлгээний шаардлагын дагуу Байгаль орчны аудит хийлгэх.	Гэрээний үнийн дүнгээр			10-р сар	Уурхайн удирдлага	-		
3	Усны нөөц ашигласны төлбөр төлөх	Үйл ажиллагааны зардал			10-р сар	Уурхайн удирдлага	-		
4	Хаягдал усны дүгнэлт гаргуулах	Үйл ажиллагааны зардал			10-р сар	Уурхайн удирдлага	-		
5	Эвдэгдсэн талбайн хэмжээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэх	Үйл ажиллагааны зардал		8-р сар		Уурхайн удирдлага	-		
6	Нөхөн сэргээлтийн дэвсгэр зураг хийлгэх.	Үйл ажиллагааны зардал		9-р сар		Уурхайн удирдлага	-		
<b>Нийт</b>		-							

**14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлagnах төлөвлөгөө*

№	БОХТ-ний биелэлтийг тайлagnахад оролцогч талууд	Тайлagnах хэлбэр	Мэдээл лийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагна х зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Харьяа байгаль орчны газарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэх.	Хэвлэмэл	2024 онд Байгаль орчны чиглэлээ эр хэрэгжүүлсэн ажлын тухай	Жил бүрийн 11-р сард	50.0	Байгаль орчны мэргэжилтэй	Нийслэлийн байгаль орчны газарт
<b>Нийт дун</b>					<b>50.0</b>		